



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/328

Номгон

Усны хяналтын тоо бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.“а”, Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 12 дугаар зүйлийн 12.1.1, Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах 21-03 гэрээний 1 дүгээр хавсралтын 20, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2/8 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний 127 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд усны хяналтын тоо бүртгэл явуулах ажлыг 2021 оны 06 дугаар сарын 07-ноос 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.


2.Усны хяналтын тоо бүртгэл явуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3.Усны тоо бүртгэлийн хяналтын тооллого явуулахад шаардагдах хүн хүч, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл гаргаж хамтран ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг), Ус цаг уур, орчны шинжилгээний төв (Ч.Оюунчимэг), Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа (Г.Хүрэлсүх), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Усны хяналтын тоо бүртгэл явуулахад шаардагдах 15,000,000 (арван таван сая) төгрөгийг Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зохицуулан санхүүжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Ганзориг)-д зөвшөөрсүгэй.

5.Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулан мэргэжил, удирдлагаар хангаж, тайлан, үр дүнг нэгтгэн Засаг даргын зөвлөлд танилцуулах, холбогдох байгууллагад хүргүүлэх зэрэг ажлыг зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Хүрэлсүх)-д үүрэг болгосугай.

6.Усны тоо бүртгэлийн ажлын явцад хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

621010833

Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын
21-ний өдрийн А/328 дугаар Захирамжийн
хавсралт



УСНЫ ХЯНАЛТЫН ТОО БҮРТЭЛ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч : Г.Хүрэлсүх -Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Б.Зүгдоржав -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны асуудал, төрийн бус байгууллага, судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн

Н.Рагчаа -Ус цаг уур орчны шинжилгээний төвийн Усны технологич инженер
Сумдын Засаг дарга, Байгаль хамгаалагч нар

Нарийн бичгийн дарга: Б.Намуун -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Байгаль орчин, аялал жуулчлал, газрын харилцаа, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн

_____оОо_____